

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн
..... 53 тоот тогтоолын хавсралт 2

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)**



“Худалдаа, хөгжлийн банкны Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам”-ын гарчиг

1. Нийтлэг үндэслэл
2. Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн
3. Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын дэг
4. Эрсдэлийн удирдлагын хорооны эрх, үүрэг
5. Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар хэлэлцэх асуудлууд
6. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогчийн эрх, үүрэг
7. Хариуцлага

**ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Худалдаа, хөгжлийн банк (цаашид **“Банк”** гэх)-ны Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид **“ЭУХ”** гэх)-ны ажиллах журам (цаашид **“Журам”** гэх)-ын зорилго нь олон улсын байгууллагууд, Базелийн хорооноос тогтоосон банкуудын үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэх зөвлөмж, стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий зохицуулагч байгууллагын заавар, журмын хүрээнд банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетитийг үнэлэх, хэрэгжилтийг хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ЭУХ нь журмын 1.1-д заасан үндсэн зорилгын хүрээнд дараах асуудлуудыг хэлэлцэж, хэрэгжилтэнд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд өөрчлөлт оруулах талаар санал, зөвлөмж гаргаж ажиллана. Үүнд:
 - 1.2.1. Эрсдэлийн удирдлагын бодлого;
 - 1.2.2. Эрсдэлийн аппетит;
 - 1.2.3. “ICAAP” тайлан буюу Internal capital adequacy assessment process;
 - 1.2.4. “ILAAP” тайлан буюу Internal liquidity adequacy assessment process;
 - 1.2.5. Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл эрх бүхий зохицуулагч байгууллагаас шаардсан стресс тест, сценарь шинжилгээ;
 - 1.2.6. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, үйлчилгээний хүү, шимтгэлийн нөхцлүүдийн өөрчлөлтүүдээс шалтгаалсан эрсдэлийн аппетитад үзүүлэх материаллаг сөрөг нөлөөлөл, уялдаа холбоог эрсдэлийн аппетитийн хэрэгжилтийн тайлангаар хянах;
 - 1.2.7. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, дотоод зохион байгуулалтын оновчтой байдал;
 - 1.2.8. Эрсдэлийн удирдлагатай холбоотой дотоод болон хараат бус, хөндлөнгийн аудитын зөвлөмж, түүний хэрэгжилт.
- 1.3. Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. **“ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо”** цаашид **“ЭУХ гэх”** гэж банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэл даах чадамж, эрсдэлийн аппетитийг хэлэлцэх, хэрэгжилтийг хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэх эрх, үүрэг бүхий дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй байнгын ажиллагаатай хороог;
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус заалтад өөрчлөлт оруулав./
 - 1.3.2. **“Эрсдэлийн удирдлага”** гэж эрсдэлийн үндсэн төрлүүд болох зээл, зах зээл, хөрвөх чадвар, комплайнс, үйл ажиллагаа, мэдээллийн технологи, цахим, нэр хүнд, стратегийн болон бусад материаллаг эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах, тэдгээрийг удирдахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэхийг;
 - 1.3.3. **“Эрсдэлийн аппетит”** гэж банкны стратегийн зорилго, зорилтууд, бизнесийн төлөвлөгөөн дээр үндэслэж, ирээдүйд чиглэсэн, эрсдэлийн зохистой түвшинг хянах зорилгоор тодорхойлсон гол эрсдэлийн үзүүлэлтүүд болон тэдгээрийн лимитийг;
 - 1.3.4. **“ICAAP”** буюу Internal capital adequacy assessment process гэж эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний баримт бичгийг;

1.3.5. “ИЛААР” Internal liquidity adequacy assessment process буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дотоод үнэлгээний баримт бичгийг тус тус ойлгоно.

Хоёр. Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүн

- 2.1. ЭУХ-ны дарга, гишүүдийг ТУЗ-ийн шийдвэрээр томилж, чөлөөлнө.
- 2.2. ЭУХ-ны дарга нь ТУЗ-ийн даргын үүргийг гүйцэтгэдэггүй байна.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус хэсгийг өөрчлөн найруулав./
- 2.3. ЭУХ-ны дарга, гишүүд нь банкны эрсдэлийн удирдлага, засаглал, хяналтын тогтолцоо, эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй загвар, судалгаа шинжилгээний арга аргачлалын талаар зохих мэдлэг, чадвар, ажлын туршлагатай байх ба эрсдэлийн удирдлагын чиглэлээрх сургалтанд хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй сайжруулан ажиллана.
- 2.4. ЭУХ-ны нарийн бичгийг ЭУХ-ны даргын санал болгосноор ТУЗ-ийн нарийн бичгийн даргын шийдвэрээр томилж, чөлөөлнө.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус хэсгийг өөрчлөн найруулав./

Гурав. Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын дэг

- 3.1. ЭУХ-ны ээлжит хурлыг улирал тутамд хуралдуулах ба дараа улирлын эхний сард багтаан зохион байгуулна.
- 3.2. ЭУХ-ны нарийн бичиг нь ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг ЭУХ-ны дарга, гишүүдэд хурал товлосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө хүргүүлсэн байна.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус хэсэгт өөрчлөлт оруулав./
- 3.3. Шаардлагатай үед ЭУХ-ны ээлжит бус хурлыг ЭУХ-ны дарга зарлан хуралдуулж болох бөгөөд хурал товлөгдсөн өдрөөс ажлын 2 хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг ЭУХ-ны нарийн бичиг нь ЭУХ-ны дарга, гишүүдэд хүргүүлсэн байна.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус хэсэгт өөрчлөлт оруулав./
- 3.4. Ээлжит болон ээлжит бус хуралд дарга, гишүүдийн олонхи оролцсоноор хурлын ирц бүрдэх бөгөөд хурлыг онлайнаар зохион байгуулж болно.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор тус хэсгийг өөрчлөн найруулав./
- 3.5. ЭУХ-ны нарийн бичиг нь хурлаар хэлэлцсэн асуудал, хурлын явц, хурал дээр гишүүд тус бүрийн хэлсэн үг, гаргасан санал, хурлын асуудал тус бүрээр оролцсон гишүүдийн дунд хураасан санал хураалтын дүн, хурлын эцсийн дүгнэлт, зөвлөмжийг хурлын тэмдэглэлд нэг бүрчлэн тэмдэглэнэ. Хурлын явцыг дуу хураагчид бичиж хадгална.
- 3.6. ЭУХ-ны нарийн бичиг нь хурлын тэмдэглэлийг уг журмын Хавсралт 1-ийн дагуу 2 хувь үйлдэж, ЭУХ-ны дарга, гишүүдээр гарын үсэг зуруулахаар хүргүүлнэ.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 57 тоот тогтоолоор тус хэсэгт өөрчлөлт оруулав./

- 3.7. ЭУХ-ны дарга, гишүүдийн гарын үсэг зурсан хурлын тэмдэглэлийн нэг эх хувийг ЭУХ-ны нарийн бичиг нь өөртөө хадгалах ба нөгөө эх хувийг ЭУХ-ны дарга, гишүүдийн лавлах хэрэгцээнд ТУЗ-ийн ажлын албанд хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх удирдлага болон Дотоод аудитын газарт хуулбарыг хүргүүлнэ.

Дөрөв. Эрсдэлийн удирдлагын хорооны эрх, үүрэг

- 4.1. Банкны эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетит, ICAAP, ILAAP тайлангуудыг хэлэлцэх, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, үйлчилгээний хүү, шимтгэлийн нөхцлүүдийн өөрчлөлтүүдээс шалтгаалсан эрсдэлийн аппетитад үзүүлэх сөрөг нөлөөллийг эрсдэлийн аппетитийн хэрэгжилтийн тайлангаар улирал бүр хянах замаар банкны ТУЗ-д дэмжлэг үзүүлэх, ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавина.
- 4.2. Эрсдэлийн удирдлагын олон улсын стандарт, хэрэгжүүлэх боломжтой тогтолцоо, Монгол улсын эрх бүхий зохицуулах байгууллагуудаас тогтоосон эрх зүйн актуудын зохицуулалттай зөрчилдөхгүй, харшлахгүй үндсэн практик аргачлалыг банкинд нэвтрүүлэх боломжоор хангахад дэмжлэг үзүүлж, ТУЗ-ийн шийдвэр гаргуулах үйл ажиллагаанд тусгуулна.
- 4.3. ЭУХ-ны дарга, гишүүд нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, банкны дүрэм, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний заавар, журмууд, Базелын хорооны холбогдох заавар зөвлөмж, олон улсын практик аргачлалын хүрээнд банкны бизнесийн үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхэд хяналт тавин, эрсдэлийн удирдлагыг ханган ажиллана.
- 4.4. ЭУХ-ны дарга нь ЭУХ-ны ажлын тайлан, хэлэлцсэн асуудлууд, гаргасан санал, зөвлөмж, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийг улирал тутам ТУЗ-д танилцуулга хийн, хараат бусаар тайлагнан ажиллана.
- 4.5. ЭУХ-ны дарга, гишүүд нь банкны бизнесийн үйл ажиллагаанд нийцсэн эрсдэлийн удирдлагын уян хатан бодлого баримтлах ба харилцагчид, хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг дээдлэн ажиллана.
- 4.6. Эрсдэлийн засаглалын зохистой бүтэц, зохион байгуулалт, дотоод хяналт, санхүүгийн салбарын хууль тогтоомж, эрх зүйн актаар хориглоогүй, хязгаарлаагүй мэдээллийн ил тод байдлыг хангах, зохицуулах эрх бүхий байгууллага болон олон нийтэд тайлагнах стандартыг тайлагналтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр сайн туршлагыг банкны үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг удирдан чиглүүлэх, зөвлөмжөөр хангах.
- 4.7. Банкны үйл ажиллагаанд сөрөг нөлөө үүсгэж болзошгүй эрсдэлийн аппетитаар тодорхойлогдсон гол эрсдэлүүдтэй холбоотой зохицуулах эрх бүхий байгууллагуудын журам, заавар, эрх зүйн актуудад гарсан өөрчлөлт, банкны салбарын бодлогын хэрэгжилтийн хяналт шалгалтад баримталдаг аргачлалд орсон өөрчлөлт, банкны бизнесийн стратегийн зорилтод үзүүлэлтүүдэд нийцүүлэн эрсдэлийн удирдлагыг сайжруулах талаар банкны гүйцэтгэх удирдлагад зөвлөмж өгөх.
- 4.8. Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавартай бодит эрсдэл, түүнээс банкны ашигт ажиллагааг бууруулах буюу цаашид нэмэгдэж болзошгүй аливаа эрсдэлийн зардлыг хамгийн бага түвшинд хадгалж, эрсдэлийн сөрөг үр дагаврыг арилгах, зогсоох, дахин давтагдаж болзошгүй нөхцөл байдлыг засах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх зөвлөмжийг банкны гүйцэтгэх удирдлагад өгнө.

- 4.9. ЭУХ-ны дарга нь банкны гүйцэтгэх удирдлагатай банкны эрсдэлийн аппетит, эрсдэлийн удирдлагын тогтолцооны олон улсын туршлага, Монголбанк болон эрх бүхий зохицуулагч байгууллагуудын хүрээнд гарсан эрх зүйн өөрчлөлтийн чиг хандлагын талаар хагас жил тутам хэлэлцэн, банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд баримтлах бодлогын талаар Гүйцэтгэх удирдлагаас санал дүгнэлт авч, хариу санал зөвлөмжийг гаргана. Тус санал зөвлөмжийг тусгасан хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн ажлын алба хариуцан гаргана.
- 4.10. ЭУХ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороотой үр дүнтэй харилцаа холбоотой байж, банкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоотой холбоотой хийгдсэн дотоод аудит (мөн хийгдсэн бол хараат бус хөндлөнгийн аудит)-ын тайлан болон цаг үеийн шаардлагаар журмын 5-р бүлэгт заасан асуудлуудын хүрээнд хагас жил тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр хурал, уулзалт хийх, хурлын материал, санал асуулга, тайлан, хурлын тэмдэглэлийг цахим шуудангаар хүлээн авч танилцах зэргээр мэдээлэл солилцоно.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 61 тоот тогтоолоор тус хэсгийг өөрчлөн найруулав./
- 4.11. ЭУХ нь шаардлагатай тохиолдолд банкны цалин, урамшууллын бодлогыг банкны эрсдэлийн аппетит, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон эрсдэлийн соёлтой нийцэж байгаа эсэх асуудлаар ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороотой уялдаа холбоог хангаж, мэдээлэл солилцон, санал хүргүүлэх болон харилцан хамтран ажиллана.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 61 тоот тогтоолоор тус хэсгийг нэмэв./

Тав. Эрсдэлийн удирдлагын хорооны хурлаар хэлэлцэх асуудлууд

- 5.1. ЭУХ-ны дарга нь хурлаар хэлэлцүүлсэн асуудлуудаар банкны ТУЗ-д улирал тутамд танилцуулан, ЭУХ-ны хурлаас гаргасан зөвлөмж, дүгнэлтийн дагуу гүйцэтгэх удирдлагаас авсан арга хэмжээний гүйцэтгэлийн талаар хараат бусаар тайлагнан ажиллана.
- 5.2. ЭУХ нь жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хуралдаж, дараах асуудлуудаар санал, зөвлөмж, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурал зарлах шийдвэр гаргах бөгөөд үүнтэй холбогдуулан банкны гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, чиглэл, мэдээллийг ТУЗ-ийн ажлын албаар дамжуулан бичгээр хүргүүлж ажиллана. Үүнд:
- 5.2.1. Банкны эрсдэлийн бодлогыг эргэн хянах, сайжруулалтын талаар Гүйцэтгэх удирдлагад санал, зөвлөмж хүргүүлэх.
- 5.2.2. Гүйцэтгэх удирдлагаас ирүүлсэн банкны эрсдэлийн аппетит, ИСААР, ИЛААР-ийн тайланг хэлэлцэх, ТУЗ-ийн хурлаар танилцуулах талаар санал гаргах.
- 5.2.3. Эрх бүхий зохицуулагч байгууллагуудаас зайлшгүй хурлаар хэлэлцүүлэхээр заасан асуудлууд болон бусад шаардлагатай асуудлуудыг тусгасан жилийн туршид мөрдөх ЭУХ-ны хурлын хуваарь, ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, батлах.
/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 06 тоот тогтоолоор тус зүйлийн 5.2.4 дэх заалтыг хасав./
- 5.2.4. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь ЭУХ-ны нарийн бичгийн хамт өмнөх оны ЭУХ-ны хурлаар хэлэлцсэн асуудлуудын хураангуй, гаргасан зөвлөмж, шийдвэр, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан болон ЭУХ-ны ТУЗ-ийн хуралд танилцуулах жилийн эцсийн ажлын тайланг бэлтгэн ЭУХ-нд танилцуулна. ЭУХ-ны дарга нь ЭУХ-ны жилийн ажлын тайланг дараагийн сард багтаан ТУЗ-ийн хуралд танилцуулан тайлагнах.

5.2.5. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь эрсдэлийн удирдлага хариуцсан газар, хэлтсүүдийн ажлын гүйцэтгэл, тэдгээрийн үр дүнгийн талаарх тайланг ЭУХ-нд танилцуулах.

/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 06 тоот тогтоолоор тус заалтуудын дугаарлалтыг өөрчлөв./

5.3. ЭУХ нь дараах асуудлуудаар улирал бүрийн эцсийн дараа сард багтаан хуралдаж, санал, зөвлөмж, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлаар танилцуулах шийдвэр гаргах ба үүнтэй холбогдуулан банкны гүйцэтгэх удирдлагад санал, зөвлөмж, чиглэл, мэдээллийг ТУЗ-ийн ажлын албаар дамжуулан бичгээр өгч ажиллана. Үүнд:

5.3.1. ТУЗ-өөр батлагдсан эрсдэлийн аппетит, ICAAP, ILAAP-ийн хэрэгжилтэд хяналт тавина.

5.3.2. Эрсдэлийн аппетит, ICAAP, ILAAP-ын тайланд тусгагдсан үзүүлэлтүүдийн гүйцэтгэлд гарсан өөрчлөлтийн үндэслэл, шалтгаан, эдгээрийн үр дагавраас банкны өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөллийн урьдчилсан дүгнэлт, танилцуулгыг хэлэлцэх.

5.3.3. Бусад шаардлагатай асуудал.

5.4. ЭУХ-ны даргын санаачлагаар ЭУХ нь дараах цаг үеийн асуудлуудаар ээлжит бусаар хуралдаж, шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн ажлын албанд мэдэгдэн, шийдвэр гаргуулахаар ТУЗ-ийн хурал зарлуулах ба үүнтэй холбогдуулан банкны гүйцэтгэх удирдлагад санал, зөвлөмж, холбогдох чиглэл өгөх. Үүнд:

5.4.1. Эдийн засгийн макро түвшин дэх орчны өөрчлөлт, банкны бизнес, стратеги төлөвлөгөөний өөрчлөлт, гадаад болон дотоод зах зээлийн орчны бусад өөрчлөлт, зохицуулах эрх бүхий байгууллагуудын журам, заавар, эрх зүйн актуудад гарсан өөрчлөлт зэргээс шалтгаалан эрсдэлийн аппетит, ICAAP, ILAAP-д орох өөрчлөлтийн талаар санал, зөвлөмж гаргаж, ТУЗ-д танилцуулах;

/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 06 тоот тогтоолоор тус зүйлийн 5.4.2 дахь заалтыг хасав./

5.4.2. Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт;

5.4.3. Банкны Гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж буй бизнес стратегийн загвар, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, эдгээрт хамааралтайгаар ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетиттай нийцтэй байдлыг хянах, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад хамааралтай асуудлууд тус бүрээр санал, зөвлөмж гаргах, дүгнэлтээр хангах;

5.4.4. Дотоод аудитын газар нь банкны эрсдэлийн удирдлагатай холбоотой аудитын тайлангаар баталгаажуулсан үр дүн, гаргасан зөвлөмж, тус зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг ЭУХ-нд улирал тутам мэдээлэх ба ЭУХ нь банкны Гүйцэтгэх захиралд аудитын тайлантай холбоотой чиглэл, зөвлөмжийг хүргүүлэх;

5.4.5. Шаардлагатай тохиолдолд банкны эрсдэлийн удирдлагатай холбоотой хараат бус хөндлөнгийн аудитын тайлан, зөвлөмж, тус зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг ЭУХ-гоор хэлэлцүүлэх ба банкны Гүйцэтгэх захиралд аудитын тайлантай холбоотой чиглэл, зөвлөмжийг хүргүүлэх;

5.4.6. Эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хуралдахаар заасан бусад асуудал.

/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 06 тоот тогтоолоор тус заалтуудын дугаарлалтыг өөрчлөв./

Зургаа. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогчийн эрх, үүрэг

- 6.1. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь Журмын 5-р бүлэгт заасан асуудлуудыг ЭУХ-гоор хэлэлцэхэд биечлэн оролцож, банкны эрсдэлийн удирдлагын талаарх шаардлагатай асуудлуудыг ЭУХ-нд танилцуулж, хараат бусаар тайлагнан ажиллана.
- 6.2. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаар эрх бүхий зохицуулах байгууллагаас мөрдүүлэхээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актанд нийцсэн, банкны салбарын нийтээрээ дагаж мөрдөхөөр хэрэгжүүлсэн олон улсын эрсдэлийн удирдлагын хөгжлийн практик чиг хандлага, Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн боловч аливаа эрх зүйн актаар хараахан батлагдаагүй байгаа арга, аргачлалыг хэрэгжүүлэх асуудлаар ЭУХ-нд танилцуулга хийх, санал оруулах зэрэг үүрэг хүлээж ажиллана.
- 6.3. Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч нь банкны хэмжээнд эрсдэлийн удирдлагыг хөгжүүлэх, олон улсын эрсдэлийн удирдлагын стандарт, тогтолцоог бий болгохоор зорьж ажиллах ба энэ ажлын хүрээнд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг чиглүүлэн, Гүйцэтгэх удирдлага ба бусад газар нэгжүүдтэй хамтран ажиллана.

Долоо. Хариуцлага

- 7.1. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол банк хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 7.2. Журмыг зөрчсөн холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран банк “Хөдөлмөрийн тухай хууль”, банкны “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.
- 7.3. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь банкны эд хөрөнгөд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран банк эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэнэ.
- 7.4. Журмыг зөрчсөн ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь банкны ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг тухайн ажилтан хариуцан арилгана.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо:

Эрсдэлийн удирдлагын хорооны хуралдаан Худалдаа, хөгжлийн банкны төв байрны ... тоот хурлын танхимд хуралдаж, хуралдааныг ЭУХ-ны дарга даргалав.

ОРОЛЦСОН нь:

ЭУХ-ны дарга

ЭУХ-ны гишүүн

ЭУХ-ны гишүүн

БАЙЛЦСАН нь:

Эрсдэл хариуцсан гүйцэтгэх захирлын орлогч

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

ТАНИЛЦУУЛСАН нь:

Танилцуулсан ажилтны албан тушаал, нэр

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ЭУХ-ны дарга

ЭУХ-ны гишүүн

ЭУХ-ны гишүүн

Хурлын тэмдэглэл бичсэн:

ЭУХ-ны нарийн бичиг